

МОНГОЛЧУУДЫН БАЙГАЛЬ ХАМГААЛАХ ЁС ЗАНШЛЫН ӨНӨӨГИЙН АЧ ХОЛБОГДОЛ

Т.ТУНГАЛАГГЭРЭЛ

МУИС, Ой судлалын тэнхим

Монголын байгаль орчин нь харьцангуй унаган төрхөөрөө хадгалагдаж үлдсэн дэлхийн цөөн орны нэгэнд ордог. Энэ нь монголчууд эрт дээр цагаас байгалиас шууд хамааралтай мал аж ахуй эрхэлж, түүнтэй зохицсон нүүдлийн аж амьдралын хэвшилтэй байсан нь түүхийн урт удаан хугацааны турш байгалиа эрхэмлэн шүтэж, хайрлан хамгаалж ирсэн онцлогтой нягт холбоотой.

Монгол түмний байгалиа хайрлан хамгаалж ирсэн уламжлалт зан үйл, экологийн мэдлэг нь хуульчлагдан мөрдөгдөж байдаг зан үйл юм. Нөгөө талаар монголчуудын байгаль хамгаалах уламжлалт зан заншил нь монгол хүний сэтгэл зүйд үнэхээр тохирсон, монгол орны байгалийн нөхцөлд зохицсон, эрхэлж буй мал аж ахуйн үйл ажиллагаатай нийцсэн байдаг. Иймээс үе дамжин уламжлагдан хэвшин тогтож иржээ.

Монголчууд байгалиа хайрлан хамгаалж, энэрэн хүндэтгэж ирсэн ёс заншил хэвшин тогтож уламжлагдсаар ирсэний гол тулгуур хүчин нь байгалийн өөрийнх нь хууль, жам ёсоор бүрэлдэн буй болсон хүрээлэн буй орчноо яг тэр хэвээр нь хайрлан хадгалж үеийн үед өвлүүлэн үлдээх үзэл бодол, итгэл үнэмшлийг шингээн тогтоох ухаарлыг төлөвшүүлж байсанд оршино. Энэ нь өргөн утгаараа экологийн боловсрол, хүмүүжил монгол оронд өнө эртнээс тавигдсан байжээ гэдгийг харуулж байна.

Харамсалтай нь өнөө үеийн залуучуудад энэ хүмүүжил алдагдсанаас байгалийг эзлэн түрэмгийлэх, хог хаягдлаар бохирдуулах, олз ашгийн хойноос хөөцөлдөх, загасыг хамаа бусаар агнах, ус, гол бохирдуулах, газрын хөрс эрэг жалга, овоог эвдэн сүйтгэх, ургамал амьтанд хүнлэг бус хандах гээд тоолж барашгүй зөрчил үүсгэж байна.

Ингэж өвөг дээдсээс уламжлагдан ирсэн ёс заншлаа ор тас мартаж, байгалиа цөлмөн доройтуулж байгаа нь өнө эртнээс тогтсон байгаль хамгаалах соёл умартсаны илрэл билээ. Энэ нь экологийн хямралд хүргэх нэгэн шалтгаан гэж үзэж болно.

Бидний өвөг дээдэс нутаг ус, хүрээлэн буй орчноо хайрлан хамгаалж, үр хүүхэддээ тогтсон ёс заншлаа уламжлуулж ирсэн нь тэдэндээ экологийн боловсрол, байгаль хамгаалах хүмүүжил олгож иржээ. Тодруулбал байгальтайгаа харьцах алхам бүрээ нүгэл буяны дэнсэнд тавьж, дараа үеийнхэндээ зааж зааварчилж, загвардан дагуулж, дууриалган хийлгэж, сургаж хүмүүжүүлдэг байсан.

Байгалиа энэрэн хүндэтгэх ёс заншилд ан амьтан, ой модыг хайрлан хамгаалах зан үйл нэн чухал байр суурьтай байсаар иржээ. Монголчууд ан ав хийж аж төрсөөр ирсэн уламжлал нь тэдний амьдралын нэгэн хэв шинж, нүүдэлчин ардын амьдрал ахуйн нэг онцлог юм. Ан амьтныг авлаж аж төрөх ёс нь энэрэн хүндэтгэх, танин мэдэхүйн ухааралд хатуу тулгуурлаж байжээ. Ан амьтныг авлах, ан гөрөөнд мордохдоо хоослон үгүйрүүлэх, сувдаглан шунахайрах, олз ашиг эрэлхийлэх бодол санаа огтхон ч байгаагүй харин гагцхүү хангайн хишгийг зөв хүртэж амьдрал ахуйгаа байгалийнхаа баялгаар тэтгэх үзэл санаа үеийн үед уламжлагдан дамжиж иржээ. Тухайлбал: Буга чоныг өөрийн гарал үүсэл, ивээн тэтгэгч далдын хүч онгон сүлдтэй холбон хүндэтгэж байсан. Бугыг урт настай амьтан гэж ихэд хүндэтгэж, хэрэв агнавал амь насанд цөвтэй гэж, буга агнасан гөрөөчинг нүгэлт хар гөрөөчин гэдэг байлаа. Агнасан тохиолдолд өвөрмөц ёс заншил гүйцэтгэдэг байжээ. Хадны бичээс сүг

зурагт буга мэт амьтныг дүрсэлсэн байдаг нь түүнийг дээдлэн хүндэтгэн ирсэн ёс заншлын ул мөр юм.

Баавгайг ойн эзэн гэж хүндэтгэн хайрлаж, зугаа цэнгэлийн маягаар агнадаггүй харин амжиргааны эрхээр агнах тохиолдолд ерөөлийн үг хэлж гуйж авдаг байсан.

Монгол хүн загасыг хайрлан хамгаалж, бэлэгдлийн дээд ёсонд хүндэлсээр ирсэн, одоо ч монгол эмэгтэйн ээмэг, зүүлт гоёлд, төрийнхөө сүлдэндээ дүрсэлсэн байдаг.

Эндээс харахад бугын эвэр, загасны мах, баавгайн өөх, доньд, мөн эдгээр амьтдын өөх, мах, арьс нь малаас нь ч илүү ашиг өгөх учир хүнс болон эмнэлэгт өргөн дэлгэр хэрэглэж болох боловч ингэвэл эдгээр амьтад ховордож устахыг мэдэж энэ ёс заншил нь дээрхи амьтдыг хамгаалж ирсэн гэлтэй.

Чоно их агнах муу, хийморь ихт амьтан болохоор лундаа үхнэ гэх. Хэрэв ийм заншил байгаагүй бол чононы арьсыг хүйтэн сэрүүн бүсийн хүмүүс, анчид, өвлийн хүйтэнд хээр малаа манан хонодог малчид өргөн хэрэглэж, чонон тоо эрс цөөрөх байсан. Тэгтэл бидний өвөг дээдэс чоно ихэсвэл малд нь хөнөөлтэй учир зөвхөн энэ үүднээс л авлалт хийж арьсыг нь хэрэглэдэг байжээ.

Туулайг тэнгэрийн хишиг, богдын бор туулай гээд, могойг лусын амьтан гээд агнадаггүй байсан нь биеэ хамгаалах чадвар муу, мөн ч ашигтай энэ амьтдыг бүрэн хамгаалж иржээ. Могойн арьс нь хөгжим, гутал, цүнх, гоёлын сав суулга гээд олон юманд ашиглаж болох, мөн хор нь анагаах өндөр чадвартай зэргээс могойг хэн хүн тааралдсан газраа цохиж агнаад байвал өдийд устах аюулд хүрсэн байх байсан.

Үнэгний үүр нүхийг уудлах суйлахыг цээрлэнэ. Үнэгэн шулам дагана гэх. Үнэгний махыг иддэггүй. Золбин зуугуул болно гэдэг. Үүнийг дагаж мөн хярсны мах ч иддэггүй байсан. Тал хээр, ойд амьдардаг хүний нөлөөнд өртөх нь их, ашиг тусаар ч их эдгээр амьтдын махыг иддэг байсан бол амьтны аймагт ихээхэн сүйрэл учрах байжээ. Үнэг хярсныг зөвхөн арьсыг нь ашигладаг байсан учир өвлийн цагт л агнадаг байжээ.

Ан амьтан, шувуу, шоргоолжны үүр ноохойг эвдэж бусниулахыг цээрлэнэ. Хожим өөрийн гэр орноо бусниулна гэж үздэг байсан. Ан амьтдыг ороо хөөцөлдөөнийх нь үед, хээлтэй үед хөхүүл нялх зулзагатай байхад нь агнадаггүй.

Шувууны өндгөнд гар хүрдэггүй, өндгөө дарсан шувууг үргээж цочоохыг цээрлэх. Шинэ нутаг сонгож буй ан амьтанг агнадаггүй зэрэг нь амьтдыг өсгөн үржүүлэх, олшруулах зорилготой хамгаалж байжээ.

Онцгой содон зүстэй ан, онцгой эвэртэй гөрөөсийг агнадаггүй байжээ. Мөн цагаан чоно, аргаль угалз, дорго, үмхий хүрнэ зэрэг амьтдыг агнадаггүй байсан. Цөөвөр чоно, аргал угалз нь угаасаа маш ховор байв.

Шувууг тэнгэрийн амьтан гээд агнадаггүй.

Монголчуудын амьтан хамгаалах заншил нь их хүмүүнлэг байжээ. Энэ нь биеэ хамгаалах чадваргүй амьтдыг сайн хамгаалдаг байсан. Тухайлбал:

- Шөнийн ангууч шувуудыг бэлчээрийн эзэн сахиул хэмээн хүндэтгэж бэгбаатар, ууль, шар, шувуу зэрэг шувуудыг харвах намнахыг цээрлэнэ.
- Цасан шуурга, хүчтэй салхи, ган, зуд, үер, мөндөр зэрэг байгалийн аюул, гал түймэрт нэрвэгдсэн буюу гол мөрөн, намаг шаварт шигдэн өөрийгөө хамгаалж чадахгүй болсон амьтан агнах ёсгүй.
- Ичдэг амьтныг ичээнд нь агнахыг хориглоно.
- Ан амьтдыг агнахдаа тарчлаан зовоох, дутуу буудах, шархдуулахыг цээрэлдэг.
- Амьтны цуглардаг хужир, шороог цусаар будаж бохирдуулдаггүй.

Дээрхи цөөн заншлаас л харахад бидий өвөг дээдэс байгаль орчин, амьтан ургамлыг нөөц даацынх нь хэмжээнд тохируулан тухайн амьтны болон өөрсдийнхөө

амжиргааны онцлог, орчны нөхцөл, биеэ хамгаалах чадварт нь тохируулж агнаж, ашиглаж хэрэглэж байсан.

Сүм дуганы ойролцоо түлшний мод огтлох, ан ав хийх, газар эрэг сэндийлэхийг хориглосон байдаг. Үүнийгээ бүрээ бишгүүрийн дуу сонсогдож, сүм дуганы бараа харагдах газарт гэж хил тогтоон заасан нь их учиртай. Тэр үеийн хүн ам нилээд төвлөрсөн газар нь сум хийд байсан. Энэ цээр нь өнөөгийн хот суурин газрын ногоон бүс гэдэг ойлголтыг эртнээс өгч олон хүн төвлөрсөн хүний хөлөөр тэр хавийн хүрээлэн буй орчин нь доройтохыг хамгаалжээ.

Мөн газрын хөрс шороо, чулууг хөрсөн дахь амьдралтай нь хамгаалж ирсэн олон заншил уламжлагдан иржээ. Чулууг хамаа бус хөдөлгөхгүй. Байрнаасаа хөдөлсөн чулуу гурван жил зовно гэдэг. Иймээс чулуу хөдөлгөхгүйн тулд малд шилбүүртэй явж заншжээ. Хурц юмаар газар зурах, хамаа бус шороо ухахад хөрсний амьтан гэр орноосоо дайжна гэдэг. Газарт гадас, шон хатгаж орхих, нүхийг таглахгүй орхихийг ихэд цээрлэнэ. Газар шархлана, газар эмгэгтэй болно гэнэ. Бидний өвөг дээдэс шороо хөдөлгөхгүй гэсэндээ гуталдаа өсгий хийдэггүй, чулуу хөндөхгүй гэсэндээ гутлынхаа хоншоорийг ээтэн хийсэн домог ч байдаг нь хөрс шороогоо яаж нандигнан хайрлаж байсны тод илрэл юм. Энд хөрс ямар чухал хүчин зүйл болох, эвдэрсэн хөрс үүсэхэд хичнээн арван жил шаардлагатай гэхчлэн биосферийн ойлголтыг өвөг дээдэс маань маш эртнээс ухааран хамгаалж иржээ.

Байгаль орчиндоо энэрэл хүндэтгэлтэй хандаж ирсэн ёс зашлуудын дотроос нийтийг хамарсан хамгийн илүү нэр хүндтэй зан үйл нь овоо тахиx, тайх ёслол байв. Монголчууд үзэсгэлэн төгөлдөр, өндөр нэр хүндтэй, ой, мод, ургамал, ан амьтны баялаг жигдэрсэн онгон тансаг, олны хайр хүндэтгэлийг татсан газар нутагт овоо тахиx ёслол үйлддэг байсан. Энэ нь бүр эртнээс хуульчлагдаж төрийн хэрэг болтлоо өргөжсөн байжээ. Иймд овоо тахидаг, догшин гэж цээрлэсэн газар нутаг, овоо тайх ёслол хийдэг газар нутгийг орчноор нь хүний нөлөөллөөс хамгаалдаг хуульчлагдсан зан үйл уламжлагдан иржээ. Энэ аугаа их заншлаараа унаган төрхөө алдаагүй, үзэсгэлэнт байгаль, бүс бүслүүрийн шинжийг хадгалсан газар нутгийг орчинтой нь төрөөс хамгаалалтанд авч хамгаалдаг тусгай хамгаалалттай газар нутгийг бидний үед өвлүүлэн өгсөн билээ.

Энэ мэт байгалиа хамгаалж байсан ёс заншил нь үе удам дамжин экологийн боловсрол олж авч байсны тод илрэл билээ. Ингэж экологийн боловсрол олгож үе дамжуулан өвлөж ирснээрээ байгаль орчноо онгон дагшнаар нь өнөө үе хүртэл хадгалж ирсэн асар их ач холбогдолтой. Эцэст нь: Байгаль, хүрээлэн буй орчноо хайрлан хамгаалж нөөц, даацынх нь хэмжээнд тохируулан хэрэглэх, экологийн соёл, боловсрол, хүмүүжил олгоход онолын мэдлэгээс гадна бидний өвөг дээдсийн байгаль, орчноо хайрлан хамгаалж ирсэн өв уламжлалаас суралцах нь зайлшгүй гэж үзэж байна.

Одоо дэлхий нийтээр байгальтайгаа зохицон амьдардаг зарчмыг баримталдаг болжээ. Монголчууд өнө эрт цагаас байгальтайгаа зохицон авахаасаа илүүтэйгээр өгөхөө бодож хүндэтгэлтэйгээр харьцаж байжээ. Дэлхий нийтийн өнөөгийн хандлага монголын өнө эртнээс байгалиа хамгаалж ирсэн зарчимтай нийцэж байна. Гэтэл өнөөгийн монголчууд бид түүнийгээ мартчихсан, орхичихсон бүр мэдэх ч хүн үгүй мэт болжээ.

Өнөө үед монголчуудын байгалиа хамгаалж байсан ёс заншил нь зөвхөн монголын хэмжээнд ачтай тустайгаар зогсохгүй дэлхий дахиныг хамарсан байгаль, хүрээлэн буй орчноо хамгаалах үйлсэд онцгой чухал юм. Иймд монголчууд ядахдаа өөрсдөө зан заншлаа мэдэж авах, цаашилбал даяарчлалын хэмжээнд түгээн дэлгэрүүлэх нэн шаардлагатай байна.